

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/25

Чойр

Хөтөлбөр батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 6 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын "Төрийн албан
хаагчийн сургалт" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, "Ажиллах нөхцөл, нийгмийн
баталгаа" хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх хөтөлбөрүүдэд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулахад
шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт суулгаж ажиллахыг нягтлан бодогч
Л.Ашидмөнх/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



С.МӨНХГЭРЭЛ

D:\2013\Tushaal

000163

ГХБХБГазрын даргын 2013 оны 125 дугаар

тушаалын 1 дүгээр хавсралт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 67 дугаар тогтоолын дагуу Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын газар байгуулагдсан. 2013 оны 10 дугаар сарын байдлаар 11 хүний бүрэлдхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын мэргэжлийн албан хаагчдын төрийн албанд мэргэшиж, туршлагажсан байдлыг судалж үзэхэд 54,5% нь төрийн албанд 1-5 жил, 27,3% нь 6-10 жил, 18,2% нь 21-ээс дээш жил ажиллаж байгаа ажилтнууд байна.

Байгууллагын одоо ажиллаж буй төрийн албан хаагчдын 2013 онд сургалтад хамрагдсан байдлыг судалж үзэхэд 3 хүн буюу 27,27% нь үндсэн мэргэжлийнхээ чиглэлээр богино хугацааны сургалтанд жилд 1-2 удаа, 1 хүн буюу 9,1% нь Солонгос улсад богино хугацааны сургалтанд хамрагдсан байна.

Байгууллагын "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийг Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батласан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр"-ийг үндэслэн боловсруулав.

2. Хөтөлбөрийн зорилго

Монгол улсын хөгжил, бүтээн байгуулалтанд хөл нийлүүлэн алхаж, аливааг мэргэжлийн өндөр түвшинд хийж чадах мэргэшсэн чадварлаг төрийн албан хаагч бэлтгэхэд оршино.

3. Хөтөлбөрийн зорилт

- 3.1. Ажлын байрандаа өөртөө суралцагч байгууллага болох зарчмаар ажиллана.
- 3.2. Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4. Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

- 4.1. Байгууллага нь төрийн албан хаагчийн сургалтад зориулсан санхүүжилтийг жил тутам төсөвтөө тусгуулах талаар ГХГЗЗГазарт санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.
- 4.2. Төрийн албан хаагчдын өөрсдийн хөрөнгө, бусад нөөц бололцоо, эх үүсвэр
- 4.3. Олон улсын хамтын ажиллагааны сайн санааны хандив, тусламжийн хөрөнгө
- 4.4. Хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 5.1. Ажлын байрандаа өөртөө суралцагч байгууллага болох зарчмаар ажиллах зорилтын хүрээнд:

Байгууллага дотроо ажлын байрнаас хөндийрүүлэхгүйгээр дараах сургалтыг зохион байгуулна.

3.1.1. Албан хаагчид 14 хоног тутамд тодорхой нэг сэдвийг судалж, сургалт хийх

3.1.2. 7 хоног бүрийн Даваа гараг бүр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, мөн албан хаагчдын зайлшгүй мэдэх шаардлагатай хууль тогтоомж, дүрэм, журмыг судлах

3.1.3. Мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагдсан албан хаагч нь дотооддоо сургалтыг зохион байгуулна.

3.1.4. Гадаад хэл, компьютерийн сургалтуудыг улиралд 1 удаа зохион байгуулах

3.2. Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. БХБЯам, ГХГЗЗГ-аараас батлагдсан буюу дэмжигдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдах сургалтуудад албан хаагчдыг оролцуулна.

3.2.2. Мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургалтуудад оролцуулна.

3.2.3. Удирдлагын академи, магистрын зэрэг олгох мөн инженерүүдийг зэрэг олгох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах

3.2.4. Төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чанартай гүйцэтгэхийн тулд аймгийн ЗДТГ-аараас зохион байгуулах сургалтад оролцуулах

3.2.5. Хавсран гүйцэтгэж байгаа бусад ажил үүргийн чиглэлээр чиглэлээр тус ажилтныг сургалтад хамруулах

3.2.6. Гадаад орнуудад мэргэшлийг дээшлүүлэх, туршлага судлуулах сургалтад хамруулах чиглэл баримтална.

6. Үр дүн

6.1. Мэргэшсэн, чадварлаг төрийн албан хаагч бүхий байгууллага болно.

6.2. Шинэ мэдлэг, туршлага бий болгосоор сайн үйл ажиллагаатай байгууллага болж төлөвшиж, иргэдэд чанар сайтай төрийн үйлчилгээ үзүүлнэ.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

ГХБХБГазрын даргын 2013 оны 4/25 дугаар

тушаалын 2 дугаар хавсралт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГАА ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь одоогоор нийт 11 ажилтантай бөгөөд үүнээс 5 хүн буюу 45.5% нь төрийн захиргааны албан хаагч, 6 хүн буюу 54.5% нь төрийн үйлчилгээний албан хаагч ажиллаж байна.

Нийт ажиллагсдыг хүйсийн хувьд авч үзвэл 4 хүн буюу 36.4% нь эрэгтэй, 7 хүн буюу 63.6% нь эмэгтэй, насны хувьд 8 хүн буюу 72.7% нь 30 хүртэлх насны, 2 буюу 18.2% нь 30-40 насны, 1 хүн 9,1% нь 45-аас дээш насны албан хаагчид байна.

Ажилтнуудын өрхийн ам бүлийн бүтцийг тодорхойлбол 5 хүн буюу 45.5% нь 3 хүртэлх ам бүлтэй, 6 хүн буюу 54.5% нь 4-5 ам бүлтэй байна.

Ажиллагсдын орон сууцны хувьд үзвэл нийтийн зориулалттай орон сууцанд 9 хүн буюу 81,8% нь, хувийн сууцанд 2 хүн 18.2% нь амьдарч байна.

2. Хөтөлбөрийн зорилго

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахад оршино.

3. Хөтөлбөрийн зорилт

- 3.1. Ажиллах нөхцлийг ажлын байрны стандартын шаардлагын түвшинд хүргэх
- 3.2. Эрүүл мэндийн болон нийгмийн асуудлуудад дэмжлэг үзүүлэх
- 3.3. Орон сууцны нөхцлөө сайжруулах, орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх

4. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- 3.1. Ажиллах нөхцлийг шаардлагын түвшинд хүргэх зорилтын хүрээнд:
 - 3.1.1. Албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл, унаагаар бүрэн хангах
 - 3.1.2 Ажлын байрны стандарт, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангуулах
 - 3.1.3. Байгууллагын тохижилтын талаар арга хэмжээг авах
- 3.2. Эрүүл мэндийн болон нийгмийн баталгааг хангах асуудлуудад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:
 - 3.2.1. Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлж биеийн тамир, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх арга хэмжээг авах

3.2.2. Эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамруулах ажлыг зохион байгуулах, эмчилгээ хийлгүүлэх, сувидалд явуулахад дэмжлэг үзүүлэх

3.2.3. Гачигдал зовлон тохиолдсон үед олгох мөнгөн тусламжийг хууль, журамд тогтоосон хэмжээгээр олгох

3.2.4. Албан хаагчийн ажлын үр дүнгээс хамааруулан шагнал, урамшууллыг жил бүр олгох

3.2.5. Чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх талаар ажилтнуудын санал хүсэлт дээр тулгуурлан төрөл бүрийн арга хэмжээг ажил бүр зохион байгуулах

3.2.6. Төрийн албаны тухай хууль болон байгууллагын дотоод журмын ажилтнуудын нийгмийн баталгааг хангахтай холбогдсон тусламж, тэтгэлгийг саадгүй олгох

3.3. Орон сууцны нөхцлөө сайжруулах, орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. Албан хаагчийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах арга хэмжээг авах

3.3.2. Шинээр гэр, хувийн орон сууц барихад дэмжлэг үзүүлэх

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүжилт, хугацаа

5.1. Байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг жил бүр үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилийн эцэст гаргаж, бүх албан хаагчдын хурлаар хэлэлцэнэ.

5.3. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгана. /ГХГЗЗГазарт хүсэлт гаргасны дагуу/

5.4. Хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

6. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

6.1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна.

6.2. Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай, урам зоригтой ажиллах, ажлын бүтээмж нэмэгдэнэ.

6.3. Эрүүл мэндийн талаарх боловсрол дээшилж эрүүл мэндээ хамгаалах арга барилд суралцана.

6.4. Орон сууцны нөхцөл, хангамж сайжирна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР